БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Хүнс, хөдөө аж ахуй газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/114/НА-СТА-ТШЗ**


Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн

Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com



Цахим хуудас:
www.audit.mn

Булган хот

2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт ........................................ 2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................ 4
3. Аудитын тайлан ........................................ 13
  3.1 Ерөнхий зүйл ........................................ 13
  3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................ 13
  3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 14
  3.4 Материаллаг байдал ........................................ 15
  3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........................................ 15
  3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................ 15
  3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................ 16
  3.8 Аудитын гол асуудал ........................................ 17
  3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................ 17
  3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................ 17
  3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................ 18
4. Аудитын илрүүлэлт ........................................ 18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................ 20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХАА | Хөдөө аж ахуй |

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichigheregi/2022A4toot

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 11

танай ______________ны № ______________ т

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Ч.АМГАЛАН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:bichighereg/2022A4tool

006020043

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **52,442,109.21** | **99,707,424.69** |
| 33 | **АВЛАГА** | 1,995,736.00 | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 1,995,736.00 | - |
| 34 | **УРЬДЧИЛГАА** | - | 7,200,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 7,200,000.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 50,446,373.21 | 92,507,424.69 |
| 351 | **Түүхий эд материал** | 45,214,424.69 | 90,064,424.69 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 45,214,424.69 | 90,064,424.69 |
| 354 | **Хангамжийн материал** | 5,231,948.52 | 2,443,000.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | |
| 35420 | Аж ахуйн материал | 1,053,729.00 | 129,840.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 5,260.00 | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | |
| 35470 | Бусад хангамжийн материал | 4,172,959.52 | 2,313,160.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **351,113,501.22** | **368,968,075.25** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 351,113,501.22 | 368,968,075.25 |
| 391 | Газар | | |
| 392 | **Биет хөрөнгө** | 338,573,155.14 | 357,678,075.09 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 323,142,390.65 | 323,142,390.65 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (19,610,648.88) | (29,415,973.32) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 148,354,000.00 | 193,354,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (130,691,500.00) | (142,466,500.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 78,319,705.10 | 78,319,705.10 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (68,644,293.26) | (71,520,552.14) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 51,919,031.26 | 51,919,031.26 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (44,215,529.73) | (45,654,026.46) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,959,112.00 | 1,959,112.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,959,112.00) | (1,959,112.00) |

| | | | |
|---|---|---|---|
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 12,540,346.08 | 11,290,000.16 |
| 39301 | Програм хангамж | 7,008,145.00 | 7,008,145.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,934,811.64) | (4,668,144.84) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,950,000.00 | 8,950,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (482,987.28) | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **403,555,610.43** | **468,675,499.94** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,921,836.00** | - |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3,921,836.00 | - |
| **413** | **Өглөг** | 3,921,836.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 3,115,736.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 806,100.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 298,400.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 507,700.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **399,633,774.43** | **468,675,499.94** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 399,633,774.43 | 468,675,499.94 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 699,279,245.10 | 699,279,245.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 699,279,245.10 | 699,279,245.10 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (445,912,115.30) | (376,870,389.79) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (408,005,058.63) | (445,429,128.02) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (37,907,056.67) | 68,558,738.23 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 146,266,644.63 | 146,266,644.63 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **403,555,610.43** | **468,675,499.94** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **909,016,534.15** | **540,018,918.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **378,352,015.15** | **110,065,562.70** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 378,352,015.15 | 110,065,562.70 |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 378,352,015.15 | 110,065,562.70 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 378,352,015.15 | 110,065,562.70 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **530,664,519.00** | **429,953,356.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 515,570,000.00 | 421,600,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 515,570,000.00 | 421,600,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,094,519.00 | 8,352,456.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,094,519.00 | 8,061,456.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | 291,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **946,923,590.82** | **471,460,180.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **946,923,590.82** | **451,499,146.47** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 904,452,532.45 | 439,621,220.01 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 247,029,492.16 | 244,925,719.00 |
| 210101 | Үндсэн цалин | 191,201,936.68 | 196,666,286.00 |
| 210102 | Нэмэгдэл | 47,841,560.48 | 40,273,514.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,985,995.00 | 7,985,919.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,324,747.47 | 31,464,625.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,950,033.73 | 22,520,099.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,479,727.53 | 2,435,307.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,977,397.39 | 1,948,246.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 442,340.60 | 414,633.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,475,248.22 | 4,146,337.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,235,803.00 | 21,582,122.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,042,925.00 | 1,833,058.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,023,468.00 | 18,475,044.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,169,410.00 | 1,274,020.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,076,763.98 | 23,336,121.22 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,449,298.00 | 1,644,378.70 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,945,600.00 | 17,166,814.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,366,280.00 | 1,356,980.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 225,000.00 | 100,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 223,700.00 | 129,000.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,866,885.98 | 2,938,948.52 |
| **2105** | **Нормативт зардал** | 573,900.00 | 347,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 573,900.00 | 347,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 913,000.00 | 3,556,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 55,000.00 | 75,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 158,500.00 | 144,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 699,500.00 | 3,337,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,999,300.00 | 10,207,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,999,300.00 | 10,207,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 169,097,540.00 | 72,719,084.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 166,127,329.00 | 67,288,442.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 176,500.00 | 180,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,596,400.00 | 1,277,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 343,025.00 | 227,075.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 688,000.00 | 3,600,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 111,286.00 | 91,467.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 410,201,985.84 | 31,482,948.25 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 379,047,915.15 | 3,854,535.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 31,154,070.69 | 27,628,413.25 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 42,471,058.37 | 11,877,926.46 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,110,100.00 | 5,990,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,995,100.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,115,000.00 | 5,990,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,360,958.37 | 5,887,926.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,360,958.37 | 5,887,926.46 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **19,961,034.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 19,961,034.00 |
| 221001 | Их засвар | - | 19,961,034.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(37,907,056.67)** | **68,558,738.23** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(37,907,056.67)** | **68,558,738.23** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **530,664,519.00** | **431,949,092.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **530,664,519.00** | **431,949,092.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 515,570,000.00 | 421,600,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 515,570,000.00 | 421,600,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 15,094,519.00 | 10,348,192.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 13,094,519.00 | 8,061,456.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,000,000.00 | 2,286,736.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **529,564,519.00** | **431,949,092.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **529,564,519.00** | **431,949,092.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **485,097,724.63** | **420,071,165.54** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 247,029,492.16 | 244,925,719.00 |
| 210101 | Үндсэн цалин | 191,201,936.68 | 196,666,286.00 |
| 210102 | Нэмэгдэл | 47,841,560.48 | 40,273,514.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,985,995.00 | 7,985,919.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,324,747.47 | 31,464,625.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,950,033.73 | 22,520,099.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,479,727.53 | 2,435,307.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,977,397.39 | 1,948,246.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 442,340.60 | 414,633.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,475,248.22 | 4,146,337.86 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,235,803.00 | 21,582,122.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,042,925.00 | 1,833,058.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,023,468.00 | 18,475,044.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,169,410.00 | 1,274,020.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,152,378.00 | 13,556,380.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,449,298.00 | 1,570,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,945,600.00 | 10,379,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,366,280.00 | 1,356,980.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 205,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 186,200.00 | 129,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 551,400.00 | 347,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 551,400.00 | 347,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 913,000.00 | 3,914,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 55,000.00 | 75,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 158,500.00 | 144,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 699,500.00 | 3,695,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,879,300.00 | 10,850,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,879,300.00 | 10,850,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 166,813,804.00 | 89,179,134.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 164,131,593.00 | 76,548,492.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 176,500.00 | 180,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,596,400.00 | 1,277,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 343,025.00 | 227,075.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 400,000.00 | 10,800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 111,286.00 | 91,467.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 197,800.00 | 4,251,885.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 197,800.00 | 4,251,885.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **44,466,794.37** | **11,877,926.46** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 37,110,100.00 | 5,990,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,995,100.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,115,000.00 | 5,990,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 7,356,694.37 | 5,887,926.46 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,356,694.37 | 5,887,926.46 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,100,000.00** | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,100,000.00** | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,100,000.00** | - |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,100,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,100,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(1,100,000.00)** | - |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 699,279,245.10 | 146,266,644.63 | (408,005,058.63) | 437,540,831.10 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **699,279,245.10** | **146,266,644.63** | **(408,005,058.63)** | 437,540,831.10 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үсийн үр дүн | - | - | (37,907,056.67) | (37,907,056.67) |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **699,279,245.10** | **146,266,644.63** | **(445,912,115.30)** | 399,633,774.43 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **699,279,245.10** | **146,266,644.63** | **(445,912,115.30)** | 399,633,774.43 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | 482,987.28 | 482,987.28 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 699,279,245.10 | 146,266,644.63 | (445,429,128.02) | 400,116,761.71 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | | 68,558,738.23 | 68,558,738.23 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **699,279,245.10** | **146,266,644.63** | **(376,870,389.79)** | 468,675,499.94 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 421,600,900.00 | 415,720,473.54 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 421,600,900.00 | 415,720,473.54 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 415,610,900.00 | 409,730,473.54 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 247,172,300.00 | 244,925,719.00 |
| 210101 | Үндсэн цалин | 198,269,400.00 | 196,666,286.00 |
| 210102 | Нэмэгдэл | 40,916,900.00 | 40,273,514.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,986,000.00 | 7,985,919.00 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,368,200.00 | 31,464,625.54 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,481,400.00 | 22,520,099.93 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,471,700.00 | 2,435,307.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,977,400.00 | 1,948,246.09 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 494,300.00 | 414,633.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,943,400.00 | 4,146,337.86 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,654,600.00 | 21,582,122.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,141,300.00 | 1,833,058.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,773,900.00 | 18,475,044.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,739,400.00 | 1,274,020.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 13,650,100.00 | 13,556,380.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,571,400.00 | 1,570,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,379,500.00 | 10,379,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,380,900.00 | 1,356,980.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 188,800.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 129,500.00 | 129,000.00 |
| 2105 | **Нормативт зардал** | 347,900.00 | 347,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 347,900.00 | 347,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,918,800.00 | 3,914,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 75,300.00 | 75,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 144,400.00 | 144,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,699,100.00 | 3,695,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 10,866,600.00 | 10,850,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,866,600.00 | 10,850,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 79,380,400.00 | 78,838,442.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 66,208,000.00 | 66,207,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 180,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,277,100.00 | 1,277,100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 617,200.00 | 227,075.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 180,000.00 | 55,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,800,000.00 | 10,800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 118,100.00 | 91,467.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,252,000.00 | 4,251,885.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,252,000.00 | 4,251,885.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5,990,000.00 | 5,990,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,990,000.00 | 5,990,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,990,000.00 | 5,990,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 421,600,900.00 | 415,720,473.54 |
| **1320** | **ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 421,600,900.00 | 415,720,473.54 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 421,600,900.00 | 415,720,473.54 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | 22.00 | 20.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 21.00 | 19.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16.00 | 14.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **10,340,692.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **10,340,692.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 10,340,692.00 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 10,340,692.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 10,340,692.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | **7,500.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 7,500.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Бэйкер тилли Далайван аудит ХХК-ийн Орхон аймаг дахь салбар ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэрлэл, хоршоо зэрэг аймгийн эдийн засгийн гол үндсэн салбарын бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагааг хэрэгжүүлдэг агентлаг.

2021 онд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөр, Салбарт хэрэгжиж буй Үндэсний хөтөлбөрүүд, Аймгийн засаг дарга, ИТХ-аас баталсан дэд

хөтөлбөр, Аймгийн эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх хүрээнд 5 зорилтыг хэрэгжүүлж ажилласан байна

- Мал сүргийн чанар, ашиг шимийг сайжруулах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Газар тариалан, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Жижиг дунд үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрлэл, хоршоо, ахуй үйлчилгээг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнс үйлдвэрлэл, нийтийн хоол, худалдаа үйлчилгээг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлого хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөцийн удирдлагаар хангаж, мэргэшил, арга зүйн дэмжлэг үзүүлэх

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 106 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн сайдын А/159 дугаар тушаал "ХХААХҮ-ийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу эдгээр 5 зорилтыг 2021 оны үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2021 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргав. Зорилго: Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2021 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр 94.2 хувь буюу 4.7 оноогоор үнэлэгдэж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг " дунд " гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 421,600.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 6,324.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,426.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,420.4 мянган төгрөгөөр буюу 0.24 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | |
| Бараа материал | 50,446.3 | 92,507.4 | 42,061.1 |
| Үндсэн хөрөнгө | 351,113..5 | 368,968.0 | 17,854.5 |
| **Нийт хөрөнгө** | **399,633.8** | **468,675.4** | **59,915.6** |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 399,633.8 | 468,675.4 | 59,915.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **403,555.6** | **468,675.4** | **65,119.8** |

Бараа материалын данс 92,507.4 мянган төгрөг болж 42,061.1 мянган төгрөгөөр өссөн нь Булган аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолоор 2021 оны 12-р сарын 16-ны өдрийн 85 дугаар тогтоолоор хөлдөөсөн үр үнэ төлбөргүй ирсэнг тусгай зориулалтын материал дээр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 368,968.0 мянган төгрөг болж 17,854.5 мянган төгрөгөөр өссөн нь 45,000.0 мянган төгрөгийн автомашин нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 468,675,4 мянган төгрөг болж 65,119.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 368,997.6 мянган төгрөгөөр буюу 40.5 хувиар, нийт зардал өмнөх оноос 475,463.4 мянган төгрөгөөр буюу 50.2 хувиар тус тус буурсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

ХХААГазар нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 547,311,5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 547,311,5 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 125,710,6 мянган төгрөгөөр бууруулан 452,019.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант онд төсвийг 2 удаа тодотгол хийж 30,418.9 мянган төгрөгөөр бууруулж, 421,600.9 мянган төгрөгөөр баталжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 421,600.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, урсгал үйл ажиллагаанд 415,720.4 мянган төгрөгийг зарцуулж, 5,880.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 415,720.4 мянган төгрөг буюу 98.6 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 2,246.5 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,903.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,072.4 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 658.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Урьд оны 1,995.7 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагын санхүүжилтийг, мөн ХААХХ төслөөс худгийн хяналтын санхүүжилт 291,0 мянган төгрөг, АЗДТГазраас 8,061.4 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Үүнээс 1,995.7 мянган төгрөгийн байгууллагад өгөх өглөгийг барагдуулж, 291,0 мянган төгрөгийг худгийн хяналтын зардалд, 2,976.4 мянган төгрөгийг ургац хураалтын зардалд, 3,805.0 мянган төгрөгийг намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдааны зардалд, 1,280.0 мянган төгрөгийг оготно устгалын зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй хэдий ч санхүүгийн тайланд Мэдээлэл технологи үйлчилгээний зардалд 10,800.0 мянган төгрөг төсөвлөн 3,600.0 мянган төгрөг төлсөн боловч 7,200.0 мянган төгрөгийг Урьдчилж төлсөн тооцоогоор бүртгэн харилцагч байгууллага руу шилжүүлсэн байна. " Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах " гэж заасан заалттай нийцэхгүй байна.Мөн бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажаагүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгддэг байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх 149 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа хоцроосон 1 мэдээлэл хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны мэдээлэл 96 хувьтай хэрэгжсэн байна.

Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажаагүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгддэг байна.Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших, Мэдээлэл технологи үйлчилгээний зардалд 10 800.0 мянган төгрөг төсөвлөн 3 600.0 мянган төгрөг төлсөн боловч 7 200.0 мянган төгрөгийг Урьдчилж төлсөн тооцоогоор бүртгэн харилцагч байгууллага руу шилжүүлсэн байна. Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтын дагуу төсвийг бодитой үнэн зөв төсөвлөж, хэмнэлттэй зарцуулах гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн тул зөвлөмж өглөө.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2,632.6 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 231.8 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Акт | 2 | 692.4 | 2 | 692.4 | - | - | |
| Албан шаардлага | - | - | - | - | - | - | |
| Зөвлөмж | 5 | 6,326.1 | 5 | 6,326.1 | - | - | |
| Нийт дүн | 7 | 7,018.5 | 7 | 7,018.5 | - | - | |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар мэдээлэл технологийн зардал, урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7,200.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 7,200.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад залруулсан алдаа байхгүй.

### 4.2 Акт

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар гаргасан алдаа зөрчилд акт хүргүүлээгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар гаргасан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлээгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Бараа материалын орлого зарлагын баримт болон шаардах хуудас тамга, тэмдгээр баталгаажаагүй, зарим анхан шатны баримтын иж бүрдэл дутуу гүйлгээ хийгддэг байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн

байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн байна.

*1.2. __Өгсөн зөвлөмж:__*

Анхан шатны баримтын иж бүрдлийг бүрдүүлэн, цахим баримтаар гүйлгээг хийж хэвших.

***2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*2.1 __Илрүүлэлт:__*

Мэдээлэл технологи үйлчилгээний зардалд 10 800.0 мянган төгрөг төсөвлөн 3 600.0 мянган төгрөг төлсөн боловч 7 200.0 мянган төгрөгийг Урьдчилж төлсөн тооцоогоор бүртгэн харилцагч байгууллага руу шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

*2.2 __Өгсөн зөвлөмж:__*

Төсвийг бодитой үнэн зөв төсөвлөж, хэмнэлттэй зарцуулах.

***3 Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал***

*3.1* Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх 149 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, хугацаа хоцроосон 1 мэдээлэл хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.Шилэн дансны мэдээлэл 96 хувьтай хэрэгжсэн байна.

Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хүнс хөдөө аж ахуйн газар | 2 | 7,200.0 | - | - | - | - | - | - | 2 | 7,200.0 |
| Дүн | | 2 | 7,200.0 | - | - | - | - | - | - | 2 | 7,200.0 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР: Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР,ЗАХИРАЛ : Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР: Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАНАЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Д.АНХБАЯР